



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/5/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер:

Утас: Цахим хаяг:

Ахлах аудитор: Ц.Лүндэгмаа

Утас: Цахим хаяг:

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайшандаг сум, 3 дугаар баг, Орхи нутгийн захирал III байр, Утас: (700) 2-27-34	ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ ДАРГА Ц.САРУУЛСАЙХАН ТАНАА
<u>2019.03.04</u> № <u>1-6/262</u> талай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Захирагчийн ажлын алба нь Төсвийн (54 дүгээр зүйлийн 54.3/26 дугаар зүйлийн 26.1)⁹-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирагчийн албаны дарга Саруул-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.26-наас 2019.02.28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 01-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.02.26-ны өдрийн 2/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Захирагчийн ажлын алба нь “Хотын захирагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хот байгуулалт, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, гадна реклам, мэдээллийн байгууламжийн талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хууль тогтоомж, бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт удирдан зохион байгуулна.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Захирагчийн ажлын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “асолус” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны *Нийт зардал* 658647.6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 13,172.93 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дансанд 25 төсөл арга хэмжээний 567.1 сая төгрөгийн зураг төсөл бүртгэлтэй байсан ба Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны албан шаардлагыг хэрэгжүүлэхдээ данснаас хасаж тайлагнасан байв. Энэ зөрчлийг арилгаж бусад хангамжийн бараа материалын дансанд 567.1 сая төгрөгийн зураг төслүүдийг орлогоор бүртгүүлж санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга, бараа материалын тодруулгын дүнд залруулга хийлгэв.
2. Бичиг хэргийн материалын дансанд 367.5 мянган төгрөгийн целлодон нүүртэй самбар бүртгэснийг хангамжийн материалын дансанд, аж ахуйн материалын дансанд 3.1 сая төгрөгийн барилгын макет бүртгэснийг бусад хангамжийн материалын дансанд, санхүүгийн байдлын тайланд данснаас хассан автобусны 2.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, үндсэн хөрөнгийн данснаас хассан зураг төслийн 2.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тайлагнагдсаныг тус тус залруулав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар захиалагчийн хяналтын зардал, цахим тендерийн хураамжийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогод бүртгэх, өөрийн орлогын төлөвлөгөөг батлуулсан эсэхийг авч үзэх нь зүйтэй.

Бусад анхаарал татсан асуудал нь нийтийн эзэмшлийн газарт мэдээлэл, сурталчилгааны самбар байршуулсан арилжааны банкуудтай газрын түрээсийн гэрээ байгуулж нэмэлт санхүүжилтийн дансаар орлого олдог. Түрээсийн орлогоос холбогдох

эрх зүйн актын дагуу орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 48868.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 47167.8 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 1.7 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Захирагчийн ажлын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллага 2017 оны 4 сард тусдаа бие даан үүсэн байгуулагдсан тул аудитын дүгнэлт гараагүй, зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,107,800.00</u>	<u>573,407,820.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
31110	Төгрөг	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	873,000.00
335	Бусад авлага	00.00	873,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	873,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,107,800.00	572,534,820.00
351	Түүхий эд материал	00.00	567,061,800.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	567,061,800.00
354	Хангамжийн материал	5,107,800.00	5,473,020.00
35410	Бичиг хэргийн материал	187,000.00	184,720.00
35420	Аж ахуйн материал	1,772,800.00	2,140,300.00
35470	Бусад хангамжийн материал	3,148,000.00	3,148,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>607,642,545.57</u>	<u>5,782,646.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	607,642,545.57	5,782,646.55
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	607,129,212.26	5,349,313.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	00.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,300,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,865,000.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,116,500.00	50,386,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,089,917.10	-46,733,166.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,184,200.00	2,184,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,776.56	-488,120.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	567,061,800.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,550,594.08	00.00
393	Биет бус хөрөнгө	513,333.31	433,333.33
39301	Програм хангамж	800,000.00	800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-286,666.69	-366,666.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>612,750,345.57</u>	<u>579,190,466.55</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>612,750,345.59</u>	<u>579,190,466.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	612,750,345.59	579,190,466.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	00.00

Замын-Үүд Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	00.00	00.00
51102	- хувийн	00.00	00.00
51103	- хувьцаат	00.00	00.00
51104	Халаасны хувьцаа	00.00	00.00
51105	Нэмж төлөгдсөн капитал	00.00	00.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	00.00
512	Хуримтлагдсан үр дүн	612,750,345.59	579,190,466.57
51210	Өмнөх үеийн үр дүн	612,750,345.59	612,750,345.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-33,559,879.02
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	00.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00.00	00.00
51600	Нөөцийн сан	00.00	00.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>612,750,345.59</u>	<u>579,190,466.57</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	628,134,364.00	625,086,856.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	567,061,800.00	576,218,156.50
120	Нийтлэг татварын бус орлого	567,061,800.00	8,746,456.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	567,061,800.00	8,746,456.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,723,856.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	567,061,800.00	22,600.00
122	Тусламжийн орлого	00.00	409,900.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	409,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	567,061,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	567,061,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,072,564.00	48,868,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,319,464.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00

Замын-Үүд Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,319,464.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,753,100.00	48,868,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,753,100.00	48,868,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	87,300,578.20	85,028,029.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,100,578.20	85,028,029.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,485,734.06	82,453,440.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,382,254.60	37,812,839.10
210101	Үндсэн цалин	29,382,254.60	37,812,839.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,332,923.26	4,504,574.18
210201	Тэтгэврийн даатгал	2,120,952.33	3,006,269.45
210202	Тэтгэмжийн даатгал	302,991.90	378,795.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	242,394.98	288,071.74
210204	Ажилгүйдлийн даатгал	60,598.00	66,909.19
210205	Эрүүл мэндийн даатгал	605,986.05	764,527.86
2104	Хангамж, бараа материалын зардал	3,450,882.00	2,484,267.29
210401	Бичиг хэрэг	781,370.00	1,233,380.00
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	319,512.00	224,887.29
210404	Ном, хэвлэл	00.00	6,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	50,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	70,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,964,400.00	00.00
210604	Урсгал засвар	7,964,400.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	677,660.00	1,058,500.00
210702	Дотоод албан томилолт	677,660.00	1,058,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,221,700.00	7,082,166.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,221,700.00	7,082,166.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,455,914.20	29,511,093.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,455,914.20	29,511,093.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,614,844.14	2,574,589.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,714,844.14	2,574,589.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,200,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,200,000.00	00.00
220001	Барилга байгууламж	2,200,000.00	00.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	540,833,785.80	540,058,826.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	573,618,705.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	573,618,705.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	540,833,785.80	-33,559,879.02

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	61,072,564.00	57,592,556.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	8,723,856.50
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,723,856.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,723,856.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,723,856.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,072,564.00	48,868,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,319,464.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,319,464.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,753,100.00	48,868,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,753,100.00	48,868,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	56,752,464.00	57,592,556.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,752,464.00	57,592,556.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,137,619.86	55,017,967.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,382,254.60	37,812,839.10
210101	Үндсэн цалин	29,382,254.60	37,812,839.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,332,923.26	4,504,574.18
210201	Тэтгэврийн даатгал	2,120,952.33	3,006,269.45
210202	Тэтгэмжийн даатгал	302,991.90	378,795.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	242,394.98	288,071.74
210204	Ажилгүйдлийн даатгал	60,598.00	74,944.19
210205	Эрүүл мэндийн даатгал	605,986.05	756,492.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,258,682.00	2,349,387.29
210401	Бичиг хэрэг	968,370.00	1,074,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	319,512.00	224,887.29
210404	Ном, хэвлэл	00.00	30,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,920,800.00	120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,264,400.00	00.00
210604	Урсгал засвар	9,264,400.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	677,660.00	1,058,500.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	677,660.00	1,058,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00

Замын-Үүд Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,221,700.00	9,292,666.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,221,700.00	9,292,666.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,614,844.14	2,574,589.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,714,844.14	2,574,589.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,320,100.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,320,100.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,320,100.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,320,100.00	00.00
220001	Барилга байгууламж	2,200,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,120,100.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,320,100.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	612,750,345.59	00.00	612,750,345.59
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	612,750,345.59	00.00	612,750,345.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	612,750,345.59	00.00	612,750,345.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-33,559,879.02	00.00	-33,559,879.02
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	579,190,466.57	00.00	579,190,466.57

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	48,868,700.00	47,167,800.57	1,700,899.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	48,868,700.00	47,167,800.57	1,700,899.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	48,868,700.00	47,167,800.57	1,700,899.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	38,569,800.00	37,812,839.10	756,960.90
210101	Үндсэн цалин	00.00	00.00	38,569,800.00	37,812,839.10	756,960.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	4,627,800.00	4,504,574.18	123,225.82
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	3,085,600.00	3,006,269.45	79,330.55
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	385,700.00	378,795.94	6,904.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	308,500.00	288,071.74	20,428.26
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	77,100.00	74,944.19	2,155.81
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	770,900.00	756,492.86	14,407.14
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	2,823,000.00	2,349,387.29	473,612.71
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	1,085,000.00	1,074,300.00	10,700.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	900,000.00	900,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	350,000.00	224,887.29	125,112.71
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	368,000.00	30,200.00	337,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	120,000.00	120,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	1,392,100.00	1,058,500.00	333,600.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	1,392,100.00	1,058,500.00	333,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	1,456,000.00	1,442,500.00	13,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	1,456,000.00	1,442,500.00	13,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	48,868,700.00	48,868,700.00	0.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	00.00	00.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	48,868,700.00	48,868,700.00	0.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	48,868,700.00	48,868,700.00	0.00

Замын-Үүд Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00	00.00	00.00	0.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	00.00	00.00	0.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	00.00	00.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	5.00	5.00	0.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	1.00	1.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	2.00	2.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00			0.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	2.00	2.00	0.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,850,166.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,850,166.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,850,166.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		00.00
210101	Үндсэн цалин		00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,850,166.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,850,166.50
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		